

### 3-ЭМТ-401. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

#### 1. ХАЯГИЙН ХЭСЭГ:

Тайланг аймаг, нийслэл, дүүргийн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагууд батлагдсан графикт хугацаанд үнэн, зөв, бүрэн мэдээлнэ.

Тухайн аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар, хариуцлагын хэлбэрийг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн үнэн зөв нөхнө. Мөн аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрийг нөхнө.

**Регистрийн дугаар** – Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон 7 оронтой регистрийн дугаарыг бичнэ.

**Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:** - Тухайн эмнэлгийн нэрийг бүтнээр бичнэ.

**Засаг захиргааны нэр код:** Аймаг, нийслэлийн албан ёсны нэрийг товчлохгүйгээр бичиж, кодыг нөхнө.

#### **Хариуцлагын хэлбэр**

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж түүн дээр бичигдсэн байдлаар нь харж нөхнө. Жишээ нь “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэсэн бол ХХК, компани гэж товчилж, үгийг хасч бичихгүй.

#### **Өмчийн хэлбэр**

Тухайн аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэрийг Улсын бүртгэлийн гэрчилгээг харж нөхнө. Харин өмчийн хэлбэр нь төрийн хамтарсан бол төрийн өмчийн эзлэх хувийг, орон нутгийн хамтарсан бол орон нутгийн өмчийн эзлэх хувийг, хувийн хамтарсан бол гадаадын өмчийн эзлэх хувийг нөхөж гадаад улсын нэрийг нөхнө. Хувийг нөхөхдөө харгалзах 3 нүдэнд нөхнө. Хэрэв хоёр оронтой бол “051” гэж өмнөх оронг “0” тавьж гүйцээн бичнэ. Кодлогч тухайн улсын код болон бусад кодуудыг “Асуулга нөхөх заавар”-ын хавсралтаас харж нөхнө.

- Монгол Улсын ”**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай**” хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд” гэнэ.
- Монгол Улсын ”**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай**” хуулийн 21 дүгээр зүйлийн 1-р хэсэгт зааснаар “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэнэ.

- Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 57 дугаар зүйлийн 1-р хэсэгт зааснаар төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хувь нийлүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн хөрөнгөтэй нийлүүлж хамтарсан үйлдвэр байгуулна.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

- Тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг нөхөхдөө эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу үйл ажиллагааны чиглэлийн нэрийг дэлгэрэнгүй тодорхой бичнэ. Жишээ нь: 8610- Эмнэлгийн үйл ажиллагаа, 8620- Шүдний болон эмнэлгийн бусад үйл ажиллагаа, 8690- Хүний эрүүл мэндийн бусад үйл ажиллагаа, 8710-Асаргаа, сувилгааны үйл ажиллагаа, 8720- Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй болон архи, мансууруулах бодист донтсон хүмүүст зориулсан төрөлжсөн асрамжийн үйл ажиллагаа, 8730- Ахмад настан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асран хамгаалах үйл ажиллагаа, 8790- Дээрх ангид ороогүй оршин суугчдад үзүүлэх асаргаа, сувилгааны үйл ажиллагаа.

## **2. ХОЛБОО БАРИХ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ**

Тухайн жилийн тайлан гаргасан мэрэгжилтний овог нэр, албан тушаал% утасны дугаар зэргийг тодорхой бичнэ.

Тайлангийн баталгааны хэсгийг тухайн жилийн тайлан гаргасан мэрэгжилтэн болон тайланг хянасан хүний нэрийг бичиж, гарын үсэг зуруулан, байгууллагын тамга дарж баталгаажуулсан байна.

### **ЭМТ-401.1. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо**

ЭМТ-401.1 тайлангийн мөрийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудыг Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу оруулсан.

#### **МӨРИЙН ДАГУУ**

Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

**Өрхийн эрүүл мэндийн төв** нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна. Аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвүүд хамаарна.

**Сум, тосгоны эрүүл мэндийн төв** нь харьяа нутаг дэвсгэрийн хүн амд өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно.

**Хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв** нь хорт хавдрын болон бусад өвчний төгсгөлийн шатанд орсон өвчтөнд хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

**Клиник** нь үндсэн, эсхүл төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулатороор болон өдрийн эмчилгээ, үйлчилгээний хэлбэрээр үзүүлэх байгууллага байна. Үүнд ШЭНЭСТ болон үүдэн хувийн эмнэлгүүд хамаарагдана.

**Амаржих газар** нь хүн амд эх барихын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

**Нийгмийн эрүүл мэндийн төв** нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна. Үүнд нийслэлийн 8 дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвүүд, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамаарагдана.

**Нэгдсэн эмнэлэг** нь долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулатороор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 4 нэгдсэн эмнэлэг, амийгийн нэгдсэн эмнэлгүүд хамаарна.

**Сувилал** нь чанар, нөөц нь тогтоогдсон рашаан, байгалийн бусад хүчин зүйлийн орд газрыг ашиглан сэргээн засах болон уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.

**Түргэн тусламжийн төв** нь түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

**Сэргээн засах төв** нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болон бусад эмнэлгээс илгээсэн өвчтөнд амбулатороор үйлчлэх, хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна.

**Тусгай эмнэлэг** нь батлан хамгаалах, хууль сахиулах албаны албан хаагч, ял эдэлж байгаа ялтан, гэмт хэрэгт холбогдуулан шалгагдаж түр саатуулагдсан иргэнд эмнэлгийн анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг үзүүлэх байгууллага байна. Үүнд: Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хууль зүйн яамны харьяа Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг, салбар эмнэлгүүд хамаарагдана.

**Тусгай мэргэжлийн төв** нь улсын хэмжээнд үндсэн, эсхүл төрөлжсөн нэг мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээг амбулатороор үзүүлж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх бөгөөд эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана. Үүнд: Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Цус судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв хамаарагдана.

**Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг** нь төрөлжсөн мэргэшлээр улсын хэмжээнд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий байгууллага байна. Үүнд: ЭХЭМҮТ, ХӨСҮТ, СЭМҮТ, АӨСҮТ, ХСҮТ, ГССҮТ

**Сувилахуйн төв** нь байнгын асаргаа сувилгаа шаардах ахмад настан, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

## **БАГАНЫН ДАГУУ**

**Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тайлан нь үндсэн орон тоогоор ажиллаж байгаа хүнээ тооцон оруулна. (Өөр байгууллагад ажиллаад хагас орон тоонд ажилладаг хүнийг үндсэн орон тоонд ажилладаг байгууллагын тоонд орно)**

**Их эмч-Бүгд:** Эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй үндсэн орон тоонд ажиллаж буй хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмчийг хамруулна. Резидент эмч нь үндсэн цалин, тэтгэлэг авч байгаа байгууллага дээрээ бүртгэгдэнэ. /Тойролт хийж байгаа байгууллагад бүртгэгдэхгүй/

**Удирдах ажилтан** гэдэгт эрүүл мэндийн байгууллагын

1. Ерөнхий захирал/Дарга
2. Дэд захирал/Орлогч дарга (стратегийн төлөвлөлт, эрдэм шинжилгээ-сургалт, эмчилгээ эрхэлсэн г.м)
3. Төвийн дарга (мэдрэл, зүрх, оношлогоо, яаралтай тусламж г.м)
4. Төв, хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
5. Хэлтсийн дарга (удирдлага, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, мэдээлэл хяналт шинжилгээ г.м)

## 6. Албаны дарга (эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар) хамаарна.

Жич: Тусламж үйлчилгээнд гардан оролцож байгаа эрхлэгч эмч, ахлагч эмч, ерөнхий нягтлан, тасгийн эрхлэгч зэргийг удирдах ажилтны тоонд оруулахгүй тооцно.

**Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнд:** Мэдээлэл зүйн, Нөхөн үржихүй, жендерийн, орчны эрүүл мэндийн, хүүхэд өсвөр үеийн эрүүл мэндийн, сэтгэцийн эрүүл мэндийн, хими, хор судлалын, хөдөлмөрийн эрүүл ахуйн, хүнсний эрүүл ахуйн, эрүүл мэндийн боловсролын, эрүүл мэндийн бодлого удирдлагын, эрүүл мэндийн зан үйлийн, эрүүл мэндийн сэтгүүл зүй, эрүүл мэндийн эдийн засгийн мэргэжилтнүүд хамаарна. Үүнээс гадна их эмч, сувилагч эм зүйч, бага эмч зэрэг мэргэжлийн хүмүүс нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж байгааг хамааруулна.

**Био-анагаахын мэргэжилтэнд:** Анагаах ухааны кибернетикч, биотехнологич, биохимич, биофизикч, бичил амь судлаач, вирусологич, дархлаа судлаач, молекул биологич, удам зүйч хамаарна.

### **Эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан дотор 21-р мөрийн Бусад мэргэжилтэнд:**

Ариутгагч, эвлэрүүлэн зуучлагч ёс зүйн ажилтан, эмгэг судлалын туслах ажилтан, яаралтай тусламжийн ажилтан (парамедик) хамаарна.

**Бусад ажилтан** гэдэг нь эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа асрагч, үйлчлэгч, манаач, жижүүр, тогтооч, галч, аж ахуйн нярав гэх мэт.

**Нийт дүн /мөр 32/:** Эрүүл мэндийн салбарын ажиллагчид бүгд дээр бусад салбарын ажиллагчид бүгд тоог нэмж гаргана.

Тус хүснэгтийн 1-р багана, 32-р мөрийн хүний их эмчийн тоо нь ЭМТ-401.3-ын 39-р баганын их эмчийн бүгдтэй тохирно.

9-р багана, 32-р мөрийн сувилагч бүгд тоо нь ЭМТ-401.4-ын 26-р баганын сувилагч бүгдтэй тохирно.

28-р багана, 32-р мөрийн Нийт ажиллагчид бүгд тоо нь 401.2-ийн Нийт ажиллагчид бүгдтэй, 401.5-ийн 13-р баганы Нийт ажиллагчидтай тохирно.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилал батлах тухай” 441 дүгээр тушаалд зааснаар:

### **ЭМТ-401.2. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын тоо, насны бүлэг, хүйсээр**

Насны бүлэг, хүйсээр гаргаж байгаа ба 1-р мөрийн бүгд нь ЭМТ-401.2 тайлан нь 401.1 ажиллагчдын нийт тоотой тэнцүү байна. Эрүүл мэндийн салбарын болон бусад салбарын эрүүл мэндийн ажиллагчдын тоог нь тусад нь гаргана.

### **ЭМТ-401.3. Эрүүл мэндийн байгууллагын их эмчийн тоо, ажлын байрандаа тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа**

Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа их эмч нарын тоог заагдсан мэргэжлээр ангилж нийлбэр нь 39-р багананд бичигдэх бөгөөд ЭМТ-401.1-ын 1-р багананд бичигдсэн тоотой тэнцүү байх ёстой. Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх сургуулийг бакалавр цолтой төгссөн буюу үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаагүй бол ерөнхий мэргэжлийн эмчид хамаарна.

Мэргэшлийн төрлөөр ялгахдаа тухайн ажлын байранд мэргэшсэн чиглэлээрээ ажиллаж байгааг бүртгэнэ.

Жишээ нь: Хүүхдийн эмчийн ажлын байранд хүүхдийн эмчээр үндсэн мэргэшил эзэмшсэн эмч ажиллах ёстой. Хэрэв хүүхдийн эмчээр үедсэн мэргэшил эзэмшээгүй эмч

хүүхдийн эмчийн ажлын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бол ерөнхий мэргэшлийн эмч гэдэгт хамруулна.

#### **ЭМТ-401.4. Эрүүл мэндийн байгууллагын сувилагчийн тоо, ажлын байрандаа тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа**

Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа сувилагчийн тоог заагдсан мэргэжлээр ангилж нийлбэр нь 26 багананд бичигдэх бөгөөд ЭМТ-401.1-ын 9-р багананд бичигдсэн тоотой тэнцүү байх ёстой. Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх сургуулийг бакалавр цолтой төгссөн буюу нарийн мэргэжил эзэмшээгүй бол ерөнхий мэргэжлийн сувилагчид хамаарна.

#### **ЭМТ-401.5 Эрүүл мэндийн байгууллагын ажиллагчдын хөдөлгөөний тайлан**

Тайлангийн эхэнд байсан буюу 1-р мөрөнд өмнөх оны тайлангийн эцэст байсан тоог заасан эмнэлгийн мэргэжилтний дагуу тавина. Тайлангийн эцэст гэсэн мөр ЭМТ-401.1-ын 32-р мөрөнд тавигдсан тоотой тэнцүү байна

#### **ЭМТ-401.6.1 Тайлангийн жилд төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж төгссөн их эмчийн тоо, мэргэжлийн индекс, зардлын эх үүсвэр**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт хариуцсан нэгж нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон зайн сургалт явуулах эрх бүхий бүх байгууллага /Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль\-ийг оруулаад тус бүрээс тайланг авч нэгтгэн гаргана.

#### **ЭМТ-401.6.2 Тайлангийн жилд төгсөлтийн дараах сургалтанд хамрагдаж төгссөн сувилагч, эмнэлгийн мэргэжлийн болон техникийн боловсролтой бусад ажилтан, мэргэжлийн индекс, зардлын эх үүсвэр**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн төгсөлтийн дараах мэргэжлийн сургалт хариуцсан нэгж нь төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон зайн сургалт явуулах эрх бүхий бүх байгууллага /Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль\-ийг оруулаад тус бүрээс тайланг авч нэгтгэн гаргана.